



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/198

Улаанбаатар хот

Захирамжийн хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1115 дугаар захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтын 2 дахь заалтын “Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 28 дугаар хороо/” гэснийг “Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 25 дугаар хороо/” гэж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1156 дугаар захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтын 5 дахь заалтын “Ус зайлуулах шугамын ажил (Сонгинохайрхан дүүрэг, 22 дугаар хороо)” гэснийг “Ус зайлуулах шугамын ажил (Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо)” гэж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1150 дугаар захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтын 3 дахь заалтын “Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 71 дүгээр сургууль/” гэснийг “Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 71 дүгээр сургууль/ ажлын дуусгал” гэж тус тус өөрчилсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1725020761